

## Санхүүгийн хяналт шалгалт хийсэн дүнгийн тухай

### НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын 2021 оны 09 сарын 15-ны өдрийн 1/17 тоот удирдамж аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2021 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Хутаг-Өндөр сумын бүрэн дунд сургууль, Уньтийн бага сургууль, Хантайн бага сургуулийн 2021 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, боловсролын холбогдох хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд оршино.

### ХОЁР.ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Л.Цэрэнбүтэд 2021 оны 09 дүгээр сарын 29-өөс төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэв.

### ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Бүрэн дунд сургууль, Уньт, Хантайн бага сургуулийн 2021 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, олговор, тэтгэмж, шагнал урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, нэмэлт орлого түүний бүрдүүлэлт, зарцуулалт, хүнсний бүтээгдэхүүн, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, үлдэгдлийн байдал, шатахууны олголт, зарцуулалт, хэтрэлт хэмнэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг хамруулав.

### ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Хутаг-Өндөр сумын бүрэн дунд сургууль нь захирал 1, сургалтын менежер 2, нийгмийн ажилтан 1, багийн багш 14, дундын багш 36.9, эмч 1, номын санч 1, бичиг хэрэг 1, нягтлан бодогч 1, нярав 1, сантехникч 1, цахилгаанчин мужаан 1, сахиул 3, тогооч 4, туслах тогооч 2, байрны жижүүр 3, үйлчлэгч 8 нийт 80.9 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж ирсэн байна.

Уньт бага сургууль нь бага ангийн багш 5, нярав 1, тогооч 1, сахиул 1, галч 1 үйлчлэгч 1, туслах тогооч 1 нийт 11 орон тоотойгоор, Хантай бага сургууль бага ангийн багш 5, нярав 1, тогооч 1, сахиул 1, галч 1, үйлчлэгч 1, туслах тогооч 1 нийт 11 орон тоотойгоор тус тус үйл ажиллагаа явуулж ирсэн байна.

Тус сургуулийн 1-р гарын үсгийг 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр хүртэл захирал Д.Ган-Эрдэнэ, 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-нийг дуусталх хугацаанд захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ж.Ариунаа, хоёрдугаар гарын үсгийг 2021 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд нягтлан бодогч Д.Баярчимэг нар зурж, төрийн санд бүртгэлийн 100041315101 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100041315401 дугаар данстайгаар, Уньт бага сургууль 100041315102 дугаар, нэмэлт санхүүжилтийн, Хантай бага сургууль 100041315103 дугаар, нэмэлт санхүүжилтийн 100041315403 дугаар данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн ба нягтлан бодох бүртгэлийг санхүүгийн тооцоолох Acclouse программаар бүртгэж хөтөлсөн байна.

#### ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Төрийн аудитаас 2020 оны санхүүгийн тайлангийн дараах үе шатны хяналтын ажил, 2021 оны санхүүгийн тайлангийн завсрын буюу аудитын төлөвлөлтийн өмнөх үе шатны ажлыг гүйцэтгэж 2019-2020 оны хичээлийн жилд П.Түмэн хүүхдийн хоолны материалын худалдан авах ажиллагааг өөрөө гүйцэтгэхдээ гэрээнд заасан мах, махан бүтээгдэхүүний хэмжээг баримтлаагүй, дутуу нийлүүлсэнээс өмнөх онд 3000.0 мянган төгрөгийн авлага үүсгэснийг 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 02/110 тоот төлбөрийн актаар төрийн аудитын дансанд 2021 оны 11 дүгээр сарын 29-ны өдөр төвлөрүүлэхээр дарга нягтлан бодогч нарт хариуцуулсаныг барагдуулаагүй байна.

Төрийн аудитын 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 01/109 тоот төлбөрийн актаар сургуулийн агуулахын хүнсний материалын үлдэгдэлд тооллого хийхэд эд хариуцагч 11202.9 мянган төгрөгийн хүнсний материал дутагдуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д/Дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх/, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4-т/Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага үрэгдүүлж, дутаасан хөрөнгийн тооцоог түүний өртөг болон зах зээлийн үнийн аль өндөрөөр хийнэ/

заалтуудыг үндэслэн төрийн аудитын дансанд 2021 оны 11 дүгээр сарын 29-ны дотор төвлөрүүлэхээр дарга, нягтлан бодогч нарт хариуцуулсаныг барагдуулаагүй байна.

Төрийн аудитаас 2021 оны санхүүгийн тайланд зөрчилгүй дүгнэлт өгсөн байна.

## ЗУРГАА. ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ

Шилэн дансны нэгдсэн сайтад тус сургууль 2021 онд мэдээлбэл зохих 161 мэдээллээс 120 мэдээллийг хугацаанд мэдээлж, 17 мэдээлэл хугацаа хоцроож, 3 мэдээлэл мэдээлээгүй байна.

## ДОЛОО. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Тус сургуулийн 2021 оны касс, харилцах, аж ахуйн баримт, өмч хөрөнгийн бүртгэл, байгууллагын удирдлагын гаргасан шийдвэр, хөдөлмөрийн дотоод журам, цалингийн карт, багшийн журнал, бараа материалын тайлан, санхүүгийн тайлан зэрэг баримт материалуудад тулгуурлан нягтлан бодогч Д.Баярчимэг, нярав Д.Түмэн нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

**8.1.Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар:** 2021 онд улсын төсвөөс 1214278.5 мянган төгрөгийн санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн дансаар 58936.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс тогтмол зардлын санхүүжилт 388833.0 мянган төгрөг, мах борлуулсаны орлого 4334.8 мянган төгрөг бүгд 1666382.7 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардалд 942773.9 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 123509.8 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 10191.3 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 369000.7 мянган төгрөг, цэвэр бохир усны зардалд 8500.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 1751.4 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 2652.3 мянган төгрөг, шуудан, холбооны зардалд 461.6 мянган төгрөг, ном, хэвлэлийн зардалд 501.2 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах зардалд 2848.6 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх зардалд 2407.4 мянган төгрөг, эм бэлдмэлийн зардалд 784.9 мянган төгрөг, хоол, хүнсний зардалд 64481.4 мянган төгрөг, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардалд 2553.5 мянган төгрөг, багаж техник хэрэгсэл 13000.0 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1700.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 614.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөрт 1440.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 12532.9 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 5121.6 мянган төгрөг, үдийн цайны зардалд 34841.6 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 800.0 мянган

төгрөг, тоног төхөрөөмж худалдан авах зардалд 17369.2 мянган төгрөг, бусад хөрөнгө бэлтгэхэд 46063.9 мянган төгрөг нийт 1661431.1 мянган төгрөг зарцуулж 2212.2 мянган төгрөг буцаан төвлөрүүлж 2739.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

Нэмэлт санхүүжилтийн талаар: 2021 онд тендерийн орлого 120.0 мянган төгрөг, ХААН банкинд химийн багш Г.Чимэгжаргалын 5284241694 тоот харилцах данс нээж иргэдээс өгсөн хандив 46039.0 мянган төгрөг, үндсэн хөрөнгө борлуулсаны орлого 1586.0 мянган төгрөг, БСУГ-аас ариутгалын бодисны мөнгө 476.0 мянган төгрөг, боловсролын чанар шинэчлэл төслийн санхүүжилт 8000.0 мянган төгрөг, Уньт багийн малчин С.Алтангэрэл 1425.0 мянган төгрөг, Тээл багийн малчин Б.Эрдэнэхүү 300.0 мянган төгрөг, 1-р багийн малчин К.Түмэнноров номч хүүхэд төсөл хэрэгжүүлэхэд хандив 500.0 мянган төгрөг, боловсролын үнэлгээний төвөөс 490.3 мянган төгрөг нийт 58936.3 мянган төгрөгийн эх үүсвэртэй захиралын болон багш нарын өрөөг засварлахад 1700.0 мянган төгрөг, 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн А/26 тушаалаар үнэлгээний хороо байгуулж 2021 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн А/36 тоот тушаалаар иргэн Л.Цэрэгнямтай гэрээ байгуулах шийдвэр гарсаны дагуу Hyundai soundy маркын автобус 42500.0 мянган төгрөгөөр нийлүүлсэн, машины даатгалд 142.5 мянган төгрөг, машины сэлбэг 1700.0 мянган төгрөг, сургуулиа сурталчилах бичлэг 1500.0 мянган төгрөг, телевизор 1490.0 мянган төгрөг, ариутгалын бодис 476.0 мянган төгрөг, принтер 2 ш 1430.0 мянган төгрөг, тендер зохион байгуулахад оролцсон иргэн Ч.Наранчимэгт цалин 222.8 мянган төгрөг, сан багшид бол , шатахуунд 80.0 мянган төгрөг, интернетийн төхөөрөмж 3564.0 мянган төгрөг, утасгүй микрофон 401.5 мянган төгрөг, ном 119.0 мянган төгрөг, багш нарын сургалт 750.0 мянган төгрөг, сургалтын материалын үнэ 165.5 мянган төгрөг, засварын материал 2148.6 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 490.3 мянган төгрөг нийт 58930.3 мянган төгрөг зарцуулж 6.0 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Ахмадын сан: Өмнөх оны үлдэгдэл 4470.7 мянган төгрөг ахмад багш Г.Болормаад буцалтгүй тусламж 300.0 мянган төгрөг, Б.Цэцэгмаад 150.0 мянган төгрөг, Т.Догожав багшид цахим гүйлт 2021 оны уралдаан зохион байгуулахад 50.0 мянган төгрөг, ахмадын баярт 1231.4 мянган төгрөг нийт 1731.4 мянган төгрөг зарцуулж 2739.3 мянган төгрөг үлдэгдэлтэй гарсан байна.

Цалин хөлс, нэмэгдэл, урамшууллын талаар: Сумын Засаг даргын 2021 оны 04 сарын 14-ний өдрийн Б/16 тоот захирамжаар 1-р улирлын урамшуулалд 45 хувиар 386.0 мянган төгрөг, 06 дугаар сарын 17-ны өдрийн Б/20 тоот захирамжаар 2 дугаар улирлын урамшуулал 45%-аар 434.2 мянган төгрөг, 09 дүгээр сарын 18-ны Б/25 тоот захирамжаар 3 дугаар улирлын урамшуулал 45%-аар 434.2 мянган төгрөг, 12 дугаар сарын 22-ны өдрийн Б/30 тоот Засаг даргын захирамжаар 4 дүгээр улирлын урамшуулал 45%-аар 434.2 мянган төгрөг нийт 1688.6 мянган төгрөг олгосон байна.

Сургуулийн захирлын 2021 оны 01 дүгээр сарын 27-ны А/10 тоот тушаалаар дотуур байрны сурагчдын ая тухтай амьдрах, суралцах боломжийг хангах ажилд санаачлагатай ажилласан дотуур байрны 2 багш, 3 жижүүрт 20-25%-аар ур чадварын нэмэгдэл 678.5 мянган төгрөг, 01 дүгээр сарын 27-ны А/11 тоот тушаалаар 2020 оны эд хөрөнгийн тооллогыг чанартай зохион байгуулсан тооллогын комиссын ажлын гишүүд 5 багш, ажиллагсадад 20-25%-аар 831.4 мянган төгрөг, 02 дугаар сарын 26-ны өдрийн А/21 тоот тушаалаар 5 багшид 10-20%-аар 555.2 мянган төгрөг, 4 сарын 05-ны өдрийн А/24 тоот тушаалаар ур чадварыг үнэлж, дүгнэх ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн болзол хангасан багш нарт ур чадварын нэмэгдэл 6 багшид 3,4,5,6 дугаар сард 10-20%-аар 3661.0 мянган төгрөг, 04 дүгээр сарын 15-ны өдрийн Б/27 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэл улс орон даяар цар тахал тархсан нөхцөл хичээл, сургалтын үйл ажиллагааг хэвийн явуулахад сургуулийн орчинд халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг ханган коронавируст халдварын үед мөрдөх заавар, зөвлөмжийг чанд мөрдүүлэн ажилласан сургуулийн эмч 2 сар үндсэн цалингийн 20%-аар 538.0 мянган төгрөг, 06 дугаар сарын 22-ны өдрийн Б/43 тоот тушаалаар хангалттай сайн ажилласан үйлчилгээний 11 ажилчидад 10-20%-аар ур чадварын нэмэгдэл 575.0 мянган төгрөг, 10 дугаар сарын 28-ны өдрийн Б/92 тоот тушаалаар Монгол улсад Худалдаа, нийтийн хоол, хоршооны салбар үүсч хөгжсөний 100 жилийн ойг тохиолдуулан аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” үйл ажиллагааны хөтөлөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохион байгуулагдсан “Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын ажил мэргэжлийн ур чадварын уралдаанд амжилттай оролцож “Цэцэрлэгийн хүүхдийн иж бүрдэл” төрөлд 2 дугаар байр эзэлсэн 2 тогоочид 15%-аар 140.0 мянган төгрөг, 10 дугаар сарын 28-ны өдрийн Б/93 тоот тушаалаар 15 багшид 10-20%-аар ур чадварын нэмэгдэл 10, 11, 12 сард 1648.8 мянган төгрөг, 11 дүгээр сарын 23-ны өдрийн Б/101 тоот тушаалаар ковид цар тахлын үед цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол чанартай хийж сургуулийн орчинд өвчлөл гарахаас урьдчилан сэргийлж байгаа үйлчлэгч нар, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад ивэдхи зүтгэлтэй ажилласан цахилгаанчин, сантехник, сургуулийн 2021 оны тайлан мэдээг цаг хугацаанд нь үнэн зөв гаргаж холбогдох газарт хүргүүлэн ажиллаж байгаа архив, бичиг хэрэг нарт ур чадварын нэмэгдэл 11 ажилласадад 10%-аар 3379.4 мянган төгрөг, 12 дугаар сарын 24-ны өдрийн Б/116 тоот тушаалаар багш нарын заах арга, ур чадварыг дээшлүүлэх, хичээлийн судалгааны арга зүйг түгээн дэлгэрүүлэхэд идэвх санаачлагатай ажилласан арга зүйн багийн гишүүдэд хавсралтаар ур чадварын нэмэгдэл 14 багшид 1-ээс 2 сараас 10-20%-аар 2293.5 мянган төгрөг, 04 дүгээр сарын 19-ны өдрийн Б/30 тоот тушаалаар 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал 68 багш ажиллагсадад 31.8-45%-аар 19033.7 мянган төгрөг, 06 дугаар сарын 14-ны Б/39 тоот тушаалаар 71 багш ажиллагсадад 8-45%-аар 18042.8

мянган төгрөг, 9 дүгээр сарын 30-ны өдрийн Б/73 тоот тушаалаар 3 дугаар улирлын үр дүнгийн урамшуулал 9-41%-аар 10931.1 мянган төгрөг, 12 дугаар сарын 20-ны өдрийн Б/113 тоот тушаалаар 4 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулал 11-60%-аар 28756.8 мянган төгрөг, 12 дугаар сарын 24-ны өдрийн Б/117 тоот тушаалаар 2021-2022 оны хичээлийн жилд болон “Ковид 19” коронавирусын цар тахлын улмаас үүссэн сурлагын хоцрогдлыг арилгах, сургуулийн орчин тохижуулах, халдвар хамгааллын дэглэмийг саиулахад ивэдхи зүтгэл, санаачлагатай ажилласан заах аргын нэгдлийн 4 –н багшид тус бүр 100.0 мянган төгрөг нийт 91465.2 мянган төгрөгийн үр дүнгийн болон ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Тайлант хугацаанд багш ажиллагсдад нийтдээ 77660.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа олгож бүрэн суутгасан байна.

Уньт бага сургууль 2021 онд улсын төсвөөс 164415.6 мянган төгрөг, мах, хүнсний бараа борлуулсаны орлого 3303.5 мянган төгрөг, боловсролын үнэлгээний төвөөс бичиг хэргийн зардалд 7.0 мянган төгрөг, БШУС-ын 2021 оны 08 дугаар сарын 12-ны А/279 тоот тушаалаар ариутгалтын зардалд 140.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс халаалт, гэрэл цахилгааны 4575.0 мянган төгрөг нийт 172445.7 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Гүйцэтгэлээр цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардалд 125038.8 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 16154.7 мянган төгрөг, гэрэл цахилгааны зардалд 975.0 мянган төгрөг, түлш халаалтын зардалд 3400.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардалд 174.3 мянган төгрөг, тээвэр шатахууны зардалд 179.0 мянган төгрөг, шуудан холбооны зардалд 46.5 мянган төгрөг, ном хэвлэлийн зардалд 80.0 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 616.5 мянган төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх зардалд 505.4 мянган төгрөг, эм бэлдмэлийн зардалд 64.5 мянган төгрөг, хоолны зардалд 6312.7 мянган төгрөг, нормын хувцас 580.1 мянган төгрөг, урсгал засварын зардалд 200.0 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардалд 116.0 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага 1383.1 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардалд 6385.7 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 100.0 мянган төгрөг нийт 155826.7 мянган төгрөг зарцуулж 10133.3 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Сургуулийн захирлын Б/32 тоот тушаалаар 1 дүгээр улирлын урамшуулалд 11 багш, ажиллагсадад 30-40%-аар 2680.0 мянган төгрөг, 6 сарын 14-ний өдрийн А/41 тоот тушаалаар 2 дугаар улирлын үр дүнгийн урамшуулалд 11 багш ажиллагсадад 34-40%-аар 2622.9 мянган төгрөг, 9 сарын 30-ны өдрийн А/74 тоот тушаалаар 3 дугаар улирлын урамшуулалд 10 багш ажиллагсадад 20-31%-аар 1872.8 мянган төгрөг, 12 сарын 20-ний өдрийн Б/115 тоот тушаалаар 4 дүгээр улирлын урамшуулалд 10 багш

ажиллагсадад 15-60 %-аар 3367.9 мянган төгрөг, 12 дугаар сарын 17-ны өдрийн Б/110 тоот тушаалаар “Тайлбартай дасгалын арга”-аар сурагч нэг бүрийг амжилттай сургасан тул үндсэн цалингийн 20%-аар 170.1 мянган төгрөг нийт 10713.7 мянган төгрөг олгосон байна.

**Хантай бага сургууль:** 2021 онд улсын төсвөөс 152838.5 мянган төгрөгийн санхүүжилт авч, мах, хүнсний ногоо борлуулсан орлого 1049.2 мянган төгрөг, боловсролын үнэлгээний төвөөс бичиг хэргийн зардалд 7.0 мянган төгрөг, БШУС-ын 2021 оны 08 дугаар сарын 12-ны А/279 тоот тушаалаар ариутгалтын зардалд 140.0 мянган төгрөг, явуулын номын богцын хоцрогдолгүй суралцагчидын чанарын шинэчлэлийн хүрээнд 4300.0 мянган төгрөг, 4447.0 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс халаалт, гэрэл, цахилгааны зардалд 4870.0 мянган төгрөг нийт 163204.7 мянган төгрөгийн эх үүсвэртэй ажилласан байна.

Гүйцэтгэлээр цалин хөлс нэмэгдэл урамшуулалын зардалд 117054.2 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлийн зардалд 15293.1 мянган төгрөг, гэрэл цахилгаан 1270.0 мянган төгрөг, түлш, халаалтын зардал 3400.0 мянган төгрөг, бичиг хэргийн зардал 99.0 мянган төгрөг, тээвэр, тээвэр шатахууны зардал 179.8 шуудан холбооны зардал 41.4 мянган төгрөг, ном хэвлэл 73.7 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгалд 290.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс 386.0 мянган төгрөг, эм бэлдмэлийн зардал 111.6 мянган төгрөг, хоол, хүнсний зардалд 10042.8 мянган зардал, нормын хувцас, зөөлөн эдлэлд 366.7 мянган, урсгал засвар 200.0 мянган төгрөг, албан томилолтын зардалд 77.2 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 442.2 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 585.8 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардалд 4682.2 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 100.0 мянган төгрөг, тоног төхөөрөмж худалдан авахад 2697.8 мянган төгрөг, бусад хөрөнгө 1376.0 мянган төгрөг нийт 158769.5 мянган төгрөг зарцуулж 4435.2 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилт: Боловсролын үнэлгээний төвөөс бичиг хэргийн зардалд 7.0 мянган төгрөг, БШУС-ын 2021 оны 08 дугаар сарын 12-ны А/279 тоот тушаалаар ариутгалтын зардалд 140.0 мянган төгрөг, явуулын номын богцын хоцрогдолгүй суралцагчидын чанарын шинэчлэлийн хүрээнд 4300.0 мянган төгрөг нийт 4447.0 мянган төгрөг орж шатахууны зардалд 442.2 мянган төгрөг, DVD тоглуулагч 1968.0 мянган төгрөг, номны богц хийх материал 200.0 мянган төгрөг, ариутгалын бодис 140.0 мянган төгрөг, монгол садын төхөөрөмж 180.0 мянган төгрөг, хөлдөөгч, уртасгагч 519.8 мянган төгрөг, таблет 990.0 мянган төгрөг, бичиг хэргийн материалд 7.0 мянган төгрөг нийт 4447.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Сургуулийн захирлын Б/31 тоот тушаалаар 1 дүгээр улирлын урамшуулалд 11 багш, ажиллагсадад 35-40%-аар 2449.0 мянган төгрөг, 6 сарын 14-ны өдрийн А/40 тоот тушаалаар 2 дугаар улирлын урамшуулалд 10 багш ажиллагсадад 35-40%-аар 2261.0 мянган төгрөг, 9 дүгээр сарын 30-ний өдрийн А/75 тоот тушаалаар 3 дугаар улирлын урамшуулалд 11 багш ажиллагсадад 30-31%-аар 1931.5 мянган төгрөг, 12 сарын 20-ний өдрийн Б/114 тоот тушаалаар 4 дүгээр улирлын урамшуулалд 11 багш ажиллагсадад 45-60 %-аар 3628.0 мянган төгрөг нийт 10269.5 мянган төгрөг олгосон байна.

**8.2 Өглөг, авлагын талаар:** Хутаг-Өндөр сумын сургууль оны эхэнд авлага 10664.5 мянган төгрөг, өглөгийн үлдэгдэлгүй, оны эцэст 29596.5 мянган төгрөг /ажилчидтай холбогдсон авлага 11230.2 мянган төгрөг, түлш халаалтын авлага 561.0 мянган төгрөг, ХАОАТ-ын авлага 645.0 мянган төгрөг, бусад зардлын тооцооны авлага 13160.2 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 4000.0/-ийн авлага, өглөгийн үлдэгдэлгүй гарсан байна.

Уньт бага сургууль 2021 оны эхэнд өр авлагагүй ба оны эцэст 180.8 мянган төгрөг /хоол /-ийн авлагатай, өглөггүй тайлан гарсан байна.

Хантай бага сургууль 2021 оны эхэнд авлага, өглөггүй жилийн эцсээр 3.6 төгрөгийн /байгууллагад/ өглөгтэй, авлаггүй тайлан гаргасан байна.

**8.3.Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт:**

2021 оны эхэнд барилга байгууламж 5568249.8 мянган төгрөг, тоног төхөөрөмж 214754.2 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 145585.1 мянган төгрөг, номын фонд 22403.0 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 54226.1 мянган төгрөг, програм хангамж 1155.0 мянган төгрөг, бусад биет хөрөнгө 58294.0 мянган төгрөг нийт 6064667.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байсанаас барилга, байгууламжид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 84 тоот тогтоолоор бага сургуулийн барилгын зөрүү 177095.2 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр авто тээврийн хэрэгсэлд 09 дүгээр сарын 01-ны өдрийн А/40 тоот тушаалаар 2020-2021 оны хичээлийн жилд “Хүүхдийн автобус” хандивын аян зохион байгуулж худалдан авсан “ASIA” маркын автобусыг 42500.0 мянган төгрөг, А/41 тоот тушаалаар БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар ирсэн хөргөгч 840.0 мянган төгрөг, буузны жигнүүр 665.0 мянган төгрөг, бэлтгэлийн ширээ 315.0 мянган төгрөг, данх 30.0 мянган төгрөг, аяга ариутгагч 700.0 мянган төгрөг, дээжийн хөргөгч 260.0 мянган төгрөг, хөлдөөгч 540.0 мянган төгрөг, 1-р хоолны тогоо 2970.0 мянган төгрөг, 2-р хоолны тогоо 440.0 мянган төгрөг, цахилгаан пийшин 3190.0 мянган төгрөг, шарах шүүгээ 1650.0 мянган төгрөг нийт 11 ширхэг гал тогооны тоног



төхөөрөмж 15560.0 мянган төгрөг, А/45 тоот тушаалаар сурагч ширээ 18 ш 1921.3 мянган төгрөг, сурагч сандал 36ш 1212.6 мянган төгрөг, А/42 тоот тушаалаар тавилга эд хогшилд БШУЯ-аас ирсэн сурагч сандал 36 ш 1212.6 мянган төгрөг, сурагч ширээ 18 ш 1921.3 мянган төгрөг, самбар 2ш 380.6 мянган төгрөг, багшийн ширээ 2 ш 464.0 мянган төгрөг, бичиг хэргийн шүүгээ 2ш 688.3 мянган төгрөг, багшин сандал 1ш 70.0 мянган төгрөг, тоглоомын тавиур 2ш 118.6 мянган төгрөг, багшийн бичгийн шүүгээ 1 ш 176.0 мянган төгрөг, багшийн ширээ 1 ш 117.4 мянган төгрөг, угтвар ширээний сандал 1ш 54.0 мянган төгрөг, суурин компьютер иж бүрэн 1 ш 1625.8 мянган төгрөг, зурагт 1ш 493.3 мянган төгрөг, угаалгын машин 1ш 482.9 мянган төгрөг, сумын орон нутгийн төсвөөс ухаалаг мэдрэгчтэй дэлгэц 1ш 6700.0 мянган төгрөг, телевизор 55 инч 3ш 4509.7 мянган төгрөг, принтер 1ш 790.3 мянган төгрөг, иргэдээс ирсэн хандиваар бий болсон суурийн компьютер 1ш 1625.8 мянган төгрөг, шкаф 2 ш 700.0 мянган төгрөг, ширээ 2 ш 40.0 мянган төгрөг, бойлуур 2 ш 400.0 мянган төгрөг, аяга 22 ш 48.4 мянган төгрөг, таваг 40 ш 26.00 мянган төгрөг, термометр 2ш 26.0 мянган төгрөг, хөшиг 4 ш 532.0 мянган төгрөг, принтер 2 ш 1430.0 мянган төгрөг, ус буцалгагч 130.0 мянган төгрөг, телевизор 32 инч 500.0 мянган төгрөг, угсардаг робот 1 ш 150.0 мянган төгрөг, ном 3 ш 55.5 мянган төгрөг, 12 дугаар сарын 28-ны А/52 тоот тушаалаар нөүт бүүк 1450.0 мянган төгрөг, ухаалаг самбар 6600.0 мянган төгрөг, matpatt 1389.0 мянган төгрөг, утасгүй микрофон 401.5 мянган төгрөг, телевизор 1490.0 мянган төгрөг, принтер 2 ш 1430.0 мянган төгрөг, ханын үзүүлэн 20 ш 1600.0 мянган төгрөг бусад 45 нэр төрлийн 6572.6 мянган төгрөгийн хөрөнгө орлогодож, 07 дугаар сарын 27-ны өдрийн А/35 тоот тушаалаар тоног төхөөрөмж 3607.0 мянган төгрөг, тавилга 282.0 мянган төгрөг, бусад 149.6 мянган төгрөг нийт 4038.7 мянган төгрөгийн хөрөнгө, 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/39 тоот тушаалаар БСШУЯ-аас 2017 онд хэрэгжүүлсэн “Шинэ зууны боловсрол” төслийн хүрээнд суурилуулсан сүлжээний төхөөрөмж ZXR105952AC SA маркын 2856.0 мянган төгрөгийн төхөөрөмж, 12 дугаар сарын 29-ны А/54 тоот тушаалаар тоног төхөөрөмжөөс 15 нэр төрлийн 1765.3 мянган төгрөгийн хөрөнгө акталж оны эцэст 6346945.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

**Уньт бага сургууль:** 2021 оны эхэнд барилга байгууламж 302400.5 мянган төгрөг, фонд 3602.4 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 4260.1 мянган төгрөг, биет бус хөрөнгө 275.0 мянган төгрөг, бусад биет бус хөрөнгө 23956.0 мянган төгрөг нийт 371471.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байснаас номын фондод боловсрол соёл урлагийн газраас 724.7 мянган төгрөгийн ном шилжүүлэн авч 372196.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

**Хантай бага сургууль:** 2021 оны эхэнд барилга байгууламж 243973.8 мянган төгрөг, тоног төхөөрөмж 18242.3 мянган төгрөг, тавилга хэрэгсэл 10063.5 мянган төгрөг, номын фонд 6385.4 мянган төгрөг, бусад үндсэн хөрөнгө 8970.3 мянган төгрөг, программ хангамж 275.0 мянган төгрөг, бусад биет бус хөрөнгө 19788.0 мянган төгрөг нийт 307698.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үлдэгдэлтэй байснаас төсвийн хөрөнгөөр тоног төхөөрөмжид DVD тоглуулагч 1698.0 мянган төгрөг, хөлдөөгч 519.8 мянган төгрөг, насос 210.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын тамгын газраас халаалтын зуух 4000.0 мянган төгрөг, 6.0 мянган төгрөгийн ном, бусад үндсэн хөрөнгөд монгол сад 180.0 мянган төгрөг, таблич 6ш 990.0 мянган төгрөг, номны богц 200.0 мянган төгрөг, БСУГ-аас сурах бичиг 516.9 мянган төгрөгийн хөрөнгө орлогодож 316789.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

**8.4. Бараа материалын хөдлөл өөрчлөлт:** 2021 оны эхний үлдэгдэл бичиг хэргийн материал 5482.8 мянган төгрөг, аж ахуйн материал 44347.6 мянган төгрөг, түлш шатах тослох материал 2921.8 мянган төгрөг, хүнсний материал 11688.4 мянган төгрөг, үдийн цайны материал 5864.8 мянган төгрөг, түлш шатах, бусад хангамжийн материал 48939.0 мянган төгрөг нийт 119244.4 мянган байсанаас төсвийн хөрөнгөөр эм 2055.3 мянган төгрөг, бичиг хэрэг 3417.2 мянган төгрөг, аж ахуйн материал 3104.0 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 3697.3 мянган төгрөг, барилгын засварын материал 9370.2 мянган төгрөг, сумын хөрөнгө оруулалтаар 12 дугаар сарын 31-ны А/376 тоот захирамжаар 7000.0 мянган төгрөгийн дотуур байрны засварын материал, хүнсний материал 59295.9 мянган төгрөг, үдийн цайны материал 36027.2 мянган төгрөг, бусад хангамжийн материал 4446.9 мянган төгрөг, бүртгэлгүй байсан эсгий хавтан 19 ш 1520.0 мянган төгрөг, эрүүл мэндийн багц 394.7 мянган төгрөг нийт 121414.0 мянган төгрөг худалдан авч зарцуулсан 133058.9 мянган төгрөг, худалдсан 4236.2 мянган төгрөг, төрийн аудитын 2021 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 02/109 тоот төлбөрийн актаар эд хариуцагчийн дутагдуулсан хүнсний материалын 11202.9 мянган төгрөгийг хасаж 07 дугаар сарын 27-ны өдрийн А/35 тоот тушаалаар аж ахуйн материалаас 92.4 мянган төгрөг, бусад хөрөнгөөс 325.0 мянган төгрөг 12 дугаар сарын 29-ны өдрийн А/54 тоот тушаалаар 209.1 мянган төгрөг нийт 626.5 мянган төгрөгийн бараа материал акталж 100421.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гарсан байна.

**Уньт бага сургууль:** 2021 оны эхний үлдэгдэл бичиг хэргийн материал 295.1 мянган төгрөг, аж ахуйн материал 2418.6 мянган төгрөг, үдийн цайн материал 1396.9 мянган төгрөг, түлш шатах тослох материал 1720.0 мянган төгрөг, хүнсний материал 3025.0 мянган төгрөг, бусад хангамжийн материал 8411.9 мянган төгрөг нийт 17267.6 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсанаас төсвийн хөрөнгөөр 19505.0 мянган төгрөгийн материал худалдан авч, шилжүүлэн эм боох материал 270.9 мянган төгрөг орлогодож

20944.3 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 3303.5 мянган төгрөгийн хүнсний материал борлуулж 12795.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гаргасан байна.

**Хантай бага сургууль:** 2021 оны эхний үлдэгдэл бичиг хэргийн материал 296.0 мянган төгрөг, аж ахуйн материал 1240.7 мянган төгрөг, түлш шатах тослох материал 4711.8 мянган төгрөг, барилгын засварын материал 20792.5 мянган төгрөг, хүнсний материал 183.5 мянган төгрөг, бусад хангамжийн материал 4793.3 мянган төгрөг нийт 32017.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсанаас төсвийн хөрөнгөөр 20620.3 мянган төгрөгийн материал худалдан авч, эм боох материал 270.9 мянган төгрөг, БСУГ-аас ариутгалын бодис 449.0 мянган төгрөг, шилжүүлэн авсан сумын орон нутгийн төсвөөс дотуур байранд 5389.5 мянган төгрөгийн барилгын материал орлогодож 42833.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 1049.2 мянган төгрөгийн хүнсний материал борлуулан 9475.1 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлан гаргасан байна.

#### ЕС. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

1. Хүнс, бараа материалын агуулахын бүртгэл хөтөлдөггүй, шаардах хуудсанд олгосон нярав, хүлээн авсан хүний гарын үсэг зурдаггүй.

2. Хүнснээс бусад бараа материалын тайланг нярав гаргаагүй.

3. Байрны багш Б.Нарантуяад 2021 оны 1 дүгээр сард захирлын А/10, А/11 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэлийг 50%-аар олгосон.

4. Багш С.Дүүрэнжаргалд 12 сарын 24-ны төлбөрийн хүсэлтээр 72.0 мянган төгрөгийн албан томилолт хаалгаагүйгээр олгосон.

5. Шилэн дансны тухай Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу хөрөнгө зарцуулах 33 шийдвэр гарсныг 12-г мэдээлж 21-ийг мэдээлээгүй

#### АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Санхүүгийн үйл ажиллагаанд хийгдсэн хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар албан шаардлага бичиж, 2 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

#### ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7 дахь заалтууд, Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын хавсалт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийлтэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар”-ын хэрэгжилт хангалтгүй байна.

## ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах.

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

Төсвийн үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж хэвшлүүлэх

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалын хавсалт “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуй нэгж, байгууллагад нийлтэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн нөхөх заавар”-ын мөрдөж ажиллах.

Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам Санхүүгийн хяналт аудитын албанд бичгээр ирүүлэх.

Илэрсэн зөрчлийг давтан гаргахгүй таслан зогсоох.

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН

УЛСЫН БАЙЦААГЧ

Л.ЦЭРЭНБҮТЭД